**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр Дугаар 167 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох нийт 21 нэрийн 102,934,023.16 (нэг зуун хоёр сая есөн зуун гучин дөрвөн мянга хорин гурван төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 71,297,501.00 (далан нэгэн сая хоёр зуун ерэн долоон мянга таван зуун нэгэн) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Отгончимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

000093

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны ... дүгээр сарын ...ны өдрийн
167 дугаар тогтоолын хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООСОН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, төрөл | Ашиглалтад орсон огноо | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл | Шинэчлэ тогтоох үнэ (төгрөг) | | | Цаашид ашиглах хугацаа (жилээр) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт үнэ (төгрөг) | |
| 1 | Серверын хайрцаг /rack/ | 3/25/2015 | 600,000.00 | 1 | 600,000.00 | 300,000.00 | 1 | 300,000.00 | 2 |
| 2 | Хэмжигч багаж /Set-530 Total station/ | 12/28/2006 | 6,225,483.00 | 1 | 6,225,483.00 | 3,000,000.00 | 1 | 3,000,000.00 | 2 |
| 3 | Долгион хүлээн авагч /TDL 450-35WRadio modem/ | 10/10/2014 | 5,000,000.00 | 1 | 5,000,000.00 | 2,500,000.00 | 1 | 2,500,000.00 | 2 |
| 4 | Хэмжих багажны суурь /Tribrach 3 pin trigger/ | 12/10/2014 | 166,667.00 | 1 | 166,667.00 | 83,334.00 | 1 | 83,334.00 | 3 |
| 5 | Байршил тодорхойлогч /Trimble R4-3 Model 62/ | 12/10/2014 | 41,578,333.00 | 1 | 41,578,333.00 | 35,000,000.00 | 1 | 35,000,000.00 | 3 |
| 6 | Цэнэглэгч /Trimble slate USB cable/ | 12/10/2014 | 125,000.00 | 1 | 125,000.00 | 62,500.00 | 1 | 62,500.00 | 3 |
| 7 | Мэдээлэл хүлээн авагч /Trimble slate controller/ | 12/10/2014 | 8,083,333.00 | 1 | 8,083,333.00 | 4,041,667.00 | 1 | 4,041,667.00 | 3 |
| 8 | Бетоны хэв /том/ | 12/30/2015 | 1,550,000.00 | 1 | 1,550,000.00 | 100,000.00 | 1 | 100,000.00 | 1 |
| 9 | Бетоны хэв /жижиг/ | 12/30/2015 | 950,000.00 | 2 | 1,900,000.00 | 150,000.00 | 2 | 300,000.00 | 1 |
| 10 | Сервер /Делл, Я720/ | 12/30/2015 | 13,413,403.16 | 1 | 13,413,403.16 | 10,000,000.00 | 1 | 10,000,000.00 | 3 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Серверийн шүүгээ | 12/30/2015 | 726,000.00 | 1 | 726,000.00 | 500,000.00 | 1 | 500,000.00 | 3 |
| 12 | Усан ванн | 12/30/2015 | 420,000.00 | 1 | 420,000.00 | 210,000.00 | 1 | 210,000.00 | 1 |
| 13 | Хатаах шүүгээ | 12/30/2015 | 1,500,000.00 | 1 | 1,500,000.00 | 1,000,000.00 | 1 | 1,000,000.00 | 2 |
| 14 | Шигшүүр суурь /лабораторийн/ | 12/30/2015 | 650,000.00 | 1 | 650,000.00 | 300,000.00 | 1 | 300,000.00 | 2 |
| 15 | Штанген циркуль | 12/30/2015 | 83,000.00 | 1 | 83,000.00 | 50,000.00 | 1 | 50,000.00 | 1 |
| 16 | Электрон жин | 12/30/2015 | 300,000.00 | 1 | 300,000.00 | 150,000.00 | 1 | 150,000.00 | 3 |
| 17 | Лазер метер | 12/31/2009 | 622,921.00 | 1 | 622,921.00 | 300,000.00 | 1 | 300,000.00 | 2 |
| 18 | Свич-2014 | 12/30/2014 | 570,800.00 | 1 | 570,800.00 | 400,000.00 | 1 | 400,000.00 | 3 |
| 19 | Багажны хайрцаг | 12/10/2014 | 1,958,333.00 | 1 | 1,958,333.00 | 1,500,000.00 | 1 | 1,500,000.00 | 3 |
| 20 | Шигшүүр | 11/1/2012 | 2,592,500.00 | 1 | 2,592,500.00 | 1,500,000.00 | 1 | 1,500,000.00 | 3 |
| 21 | Пресс /шоо хэлбэрийн дагалдах/ | 11/1/2012 | 14,868,250.00 | 1 | 14,868,250.00 | 10,000,000.00 | 1 | 10,000,000.00 | 2 |
| Нийт дүн | | | 101,984,023.16 | 22 | 102,934,023.16 (нэг зуун хоёр сая есөн зуун гучин дөрвөн мянга хорин гурван төгрөг арван зургаан мөнгө) | 71,147,501.00 | 22 (хорин хоёр) | 71,297,501.00 (далан нэгэн сая хоёр зуун ерэн долоон мянга таван зуун нэг) | |